



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

**Хамтлаг шалгаруулах уралдааны
болзол батлах тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 12 дугаар зүйл, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. “Улсын тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг” шалгаруулах болзлыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалыг салбар байгууллагуудад сурталчлах, хэрэгжилтийг ханган ажиллахыг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын хэлтэс /Г.Одбаатар/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2007 оны 385 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000314

Биеийн тамир, спортын газрын даргын 2017
оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/...
тоотгушаалын хавсралт 183

“УЛСЫН ТЭРГҮҮНИЙ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

Зорилго: “Биеийн тамир, спортын тухай” хуулийн гуравдугаар бүлгийн 12 дугаар зүйл, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага дахь Биеийн тамир, спортын хамтлагаар дамжуулан ажиллагчдыг биеийн тамир, спортоор хичээллүүлэх таатай нөхцөл, боломж, орчинг бүрдүүлэх, бие бялдрын соёл, боловсролыг олгоход мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, тэднийг биеийн тамирын төрөл бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээ, тэмцээнд тогтмол амжилт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн Хамтлагийг алдаршуулах, сурталчлахад оршино.

Нэг. Уралдааны үе шат, бүрдүүлэх материал

Болзолт уралдааныг улсын хэмжээнд 2 үе шаттайгаар зохион явуулна.

- Нэгдүгээр үе шат:

Аймаг, нийслэл, дүүрэг, зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллагын хэмжээнд;

- Хоёрдугаар үе шат:

Улсын хэмжээнд;

Нэгдүгээр үе шатны болзолт уралдааныг Аймаг, нийслэл, дүүрэг, зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллага дахь Биеийн тамир, спортын байгууллагууд нь нутаг дэвсгэр болон салбарын хэмжээнд “Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг” шалгаруулах болзолт уралдааныг жил бүр зарлаж, шалгарсан байгууллагын холбогдох материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар (биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага)-т жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ. Үүнд:

- Харьяа Биеийн тамир, спортын төрийн байгууллагын албан тоот
- Тухайн “Биеийн тамир, спортын хамтлаг”-ийн товч танилцуулга
- Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тайлан болон баталгаажуулсан DVD, VCD, фото зураг, дүрс бичлэг, г.м...

Жич: Нийслэл, Дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд “Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг” шалгаруулах болзолт уралдааныг жил бүр зарлаж, шалгарсан нэг (1) байгууллагын холбогдох материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар (биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага) хүлээн авч, шалгаруулалтыг явуулна.

Хоёрдугаар үе шатны болзолт уралдааны шалгаруулалтад ирсэн материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар (биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага) хүлээн авч, шалгаруулалтыг явуулна.

Хоёр. Шалгуур үзүүлэлт

Болзолт уралдаанд ирүүлэх материалд зөвхөн тухайн жилд зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ, тэмцээн, бусад холбогдох ажлуудыг товч, ойлгомжтой байдлаар ангилан бичнэ. Үүнд:

- 2.1. Хамтлагийн тухайн жилийн ажлын төлөвлөгөөг байгууллагын удирдлагатай зөвшилцөн батласан үйл ажиллагааны төлөвлөгөө /гэрээ/, түүний биелэлт /холбогдох материалыг хавсаргах/;
- 2.2. Биеийн тамир, спортын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 12 дугаар зүйл "Аж ахуйн нэгж байгууллага дахь биеийн тамир" заалтын хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүн, үзүүлэлт;
- 2.3. Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүн, үзүүлэлт;
- 2.4. "Чийрэгжүүлэх, бялдаржуулах байгууллага, үйлчилгээ" 5538:2005 нийтлэг шаардлага стандартаар батлагдсан Монгол улсын 7-64 насны хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүн, үзүүлэлт /хамрагдагчдын дүн мэдээ, тогтмолжуулсан эсэх, бие бялдрын түвшингийн үзүүлэлт ахисан байдлыг илтгэх материалыг хавсаргах/;
- 2.5. Хамтлагийн тухайн жилд зарцуулсан хөрөнгө санхүүгийн тооцоо /хөрөнгө оруулалт, хандив, дэмжлэг, тусламж, г.м/
- 2.6. Хамтлагийн хүрээнд тухайн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохиосон арга хэмжээний тоо, үр дүн, үзүүлэлт;
- 2.7. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд шаардагдах хэрэглэл материал, тохижуулсан танхим, заал талбайн талаарх мэдээлэл, тоон үзүүлэлт;
- 2.8. Аймаг, нийслэл, дүүрэг, улс, хот, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хамт олноос оролцуулсан байдал, гаргасан амжилтын талаарх мэдээлэл, тоон үзүүлэлт;
- 2.9. Нийт ажилчдын дунд зохиосон тэмцээн, нийтийг хамарсан арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүн, тоон үзүүлэлт /холбогдох материалыг хавсаргах/

Гурав. Дүгнэх журам

- 3.1. Нэгдүгээр үе шатны болзолт уралдааныг Аймаг, нийслэл, дүүрэг, зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллага дахь Биеийн тамир, спортын байгууллагууд зарлаж, шалгаруулалтыг зохион явуулж, урамшуулж, алдаршуулна.
- 3.2. Хоёрдугаар үе шатны шалгаруулалтад ирүүлсэн материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газраас томилогдсон Ажлын хэсэг судлан үзэж, шалгуур үзүүлэлт бүрт 10 хүртэлх оноо өгч, их онооны системээр байр эзлүүлж 3 хүртэлх байгууллагыг "Улсын тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг"-аар шалгаруулна.
- 3.3. "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГ"-аар шалгарсан байгууллага тус бүрт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын "БАТЛАМЖ", 500.000 /таван зуун мянган/ төгрөг, спортын хэрэглэл материалаар шагнаж урамшуулна.

Дөрөв. Сурталчилгаа

- 4.1. "Улсын тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг"-аар шалгарсан байгууллагыг хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл, байгууллагын вэб сайтад байршуулан сурталчилж алдаршуулна.

---oOo---